



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/609

Есөнбулаг

Мотоциклийн хөдөлгөөнийг түр  
хугацаагаар хориглох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Замын зорчих хэсэгт халтиргаа гулгаа үүссэнтэй холбогдуулан механикжсан тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, амь насанд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор аймаг болон сумдын суурин газарт мотоциклоор замын хөдөлгөөнд оролцохыг 2023 оны 11 сарын 15-ны өдрөөс 2024 оны 03 сарын 01-ний өдрийг дуустал түр хугацаагаар хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, илэрсэн зөрчлийг арилгуулах, иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлгийг хүргэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүйн хэлтэс (Х.Лхагважав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР